

“Монгол хэлний гурван ном”-ын авианзүйн зарим онцлог

С. Батхишиг\*

18-р зууны сүүлээр Чусоны `Түүхийн хүрээлэн`-гээс хэвлэгдэн гарсан *Мун-о Ну-гол-дэ* (蒙語老乞大), *Чоб-хэ Мун-о* (捷解蒙語), *Мун-о Юү-хэ* (蒙語類解) хэмээх “Монгол судлалын гурван ном”-ыг 20-р зууны дунд үеэс анхааран судлах болсноор эрдэм шинжилгээний хүрээнд танил болсон билээ. Энэхүү гурван ном нь тухайн үеийн монгол ярианы хэлийг монгол бичиг болон солонгосын хан үсгээр тэмдэглэснээрээ монгол хэлний авианзүйн ховор баримт болж байна. Ялангуяа *Мун-о Ну-гол-дэ*<sup>1</sup>-гийн хэл нь бодот аж амьдралын харилцан ярианы агуулгатай ба монгол бичгийн хэлний бус ярианы дуудлагыг шууд тэмдэглэсэн зүйл их харагдана. *Мун-о Юү-хэ*<sup>2</sup> нь монгол бичгийн хэлээр бичсэн текстийг хангылаар хадаж бичсэн ба монгол бичгийн эх нь бичгийн хэлний дүрмээр бичсэн ба хангылаар галиглахдаа ч бичгийн хэлний дүрмээс зөрсөн зүйл бараг байхгүй. *Чоб-хэ Мун-о*<sup>3</sup> нь зүйл хуваасан толийн агуулгатай ба нөгөө хоёр номоосоо ялгаатай нь хангылаар монгол бичгийн хэлний дүрмийн дагуу тэмдэглэсэн. Өөрөөр хэлбэл, *Мун-о Юү-хэ* ба *Чоб-хэ Мун-о* нь ярианы хэлний махбод төдий л тохиолдохгүй.

1. Бичлэгийн онцлог

- *Мун-о Ну-гол-дэ*-гийн хангыл үсгийн галиг монгол бичгийн эхээ хуулбарлан галигласан шинжтэй боловч монгол бичгийн эхээсээ зөрж тухайн үеийн ярианы хэлний дуудлагаар тэмдэглэсэн зүйл хангыл галигт олонтоо тохиолдоно. Жишээ нь (0102b)-д,

a. m.b. üge-yi > kh. ügīg                      b. m.b. örüsüjü > kh. örshödž  
han. ügə-gi    han. örsyejü

- Монгол бичгийн адил дүрс бүхий авиануудыг хангыл галигт нэг үсгээр ялгаж тэмдэглэсэн. Жишээ нь,

a. 兀    ㄣ (o)    b. 兀    ㄣ (ö)                      c. ㄣ    ㄣ (t)                      d. ㄣ    ㄣ (g)  
          ㄣ (u)                                      ㄣ (ü)                                      ㄣ (d)                                      ㄣ (k)

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол Хэл Соёлын Сургууль

<sup>1</sup> *Мун-о Ну-гол-дэ*-гийн монгол хэлний онцлогийн талаар Ким Пан Хань(1962, 1963, 1965, 1967) бичсэн бол И Ги Мунь(1964) Гэсэрийн туужтай харьцуулан авианзүй, үгзүйн талаар дурдсан. Мөн Wayne Schleppe(1997) *Мун-о Ну-гол-дэ*-гийн ярианы хэлний онцлогийг судалсан ба И Сөн Гюү(1998, 2002) үгзүйн талаас нь судалсан байна.

<sup>2</sup> *Мун-о Юү-хэ*-гийн тухайд Ким Пан Хань(1971), Сун Ги Жүн(1985), И Сөн Гюү(2002) нарын бүтээл хэвлэгджээ.

<sup>3</sup> *Чоб-хэ Мун-о*-гийн талаар Ким Пан Хань(1963), И Сөн Гюү(1994, 1997, 2002, 2004) нарын судалгааны бүтээл гарчээ.

- Монгол хэлний гурван ном нь бичлэгийн хувьд ерөнхийдөө адил зарчимтай ба *Чоб-хэ Мун-о* (捷解蒙語) нь u/ü; γ/g; r/l<sup>4</sup> зэргийн дуудлагыг ялгаж бинт тэмдэглэсэн.

## 2. Авианы тохирол

### 2.1. Эгшигийн тохиролцоо

*Богино эгшиг.* Монгол хэлний долоон эгшиг авиа(a, e, i, o, ö, u, ü)-г тохирох хангыл үсгээр галигласнаас u, ü хоёрыг нэг үсгээр галигласан. Энэ нь монгол хэлний эгшиг зохицох ёс(vowel harmony)-ны дагуу эр эм эгшиг нэг үгэнд хамт ордоггүй зарчмаар төвөггүй уншигдах учраас солонгос хэлэнд дутсан авиалбарыг нэг үсгээр тэмдэглэсэн бололтой.

*é эгшиг авиалбарын хувилбар.* Солонгос үсгээр галигласан 'Монгол хэлний гурван ном'-д монгол бичгийн хэлний e(ᠡᠭᠡᠨᠢᠯᠢ)ᠦ-г ᠡ(ᠡ)-гөөр тэмдэглэсэн. Орчин цагийн өвөрлөгчдийн аялгуунд уруулын бус, хэлний дундуурх, эм сул, урагшилсан богино é эгшиг авиалбарын хувилбар буй. Цахар, сөнид аялгууны э нь одоогийн халх аялгууны e-тэй тохирдог байна. Бусад өвөрлөгчдийн э халхын e-гээс илүү ö-тэй ойролцоо дуудлагатай хэлэгддэг. Ер нь 'Монгол хэлний гурван ном' нь өвөрлөгчдийн аль нэг аялгуунд суурилсан нь тодорхой тул өвөрлөгчдийн э-г тэмдэглэсэн байх боломжтой юм. Нөгөө талаар Солонгосын хангыл үсгийн дуудлагаар тухайн үед монгол хэлний e-тэй хамгийн ойр дуудлагатай авиагаар дүйцүүлсэн буй за.

< ö > эгшиг. Мун-о Ну-гол-дэ-д үгийн эцэст болоод үгийн дунд тохиолдохгүй. Энэ нь тухайн үеийн монгол хэлний авианы онцлогтой холбоотой байсан болов уу. И Ги Мүн(Lee Ki Moon) "ö(ᠥ) үсэг нь үгийн эхэнд дангаараа юм уу, č, j, n-ээр эхэлсэн үеийн эхэнд тохиолдох ба b, d, k, m, s, t-ээр эхэлсэн үед ü(ᠥ) мөн 2-р үеэс хойш мөн ü(ᠥ)-ээр тэмдэглэнэ" гэжээ<sup>5</sup>. Гэвч үгийн эхэнд č, j, n-ээс гадна b-ээр эхэлсэн үед тохиолдоно. Сурвалжийг хангыл үсгээр галиглахдаа эгшиг бүрт тохирох авиа үсгийг тодорхой тэмдэглэхийг зорьсон ба u(ᠥ), ü(ᠥ)-гийн тохиолдолд тухайн үг эр үг үү, эм үг үү гэдгээс тодорхой учир үсгийн дутамжийг нөхсөн бололтой. Хэрвээ č, j, n, b-гийн дараа ö тэмдэглэж болж байсан юм бол яагаад одоо монгол хэлний төв аялгуу болон ихэнх нутгийн аялгуунуудад č, j, n, b-гийн дараа ö-гөөр хэлэгддэг газар č, j, n, b-гийн дараа ü-г тэмдэглэсэн бэ гэдэг асуудал гарна. Жишээ нь,

*Мун-о ну-гол-дэ.* jüb ~ jöb; jüblældüji ~ jöbleldüji; čülbäjü ~ čölbejü;

*Мун-о юү-хэ.* süni düli ~ kh. shönö düli ~ shöni düli; түбшин ~ kh. түвшин ~ tövshin

Энэ нь č, j, n гийгүүлэгчийн дараа ö-г (ᠥ)-гээр бусад гийгүүлэгчийн дараа (ᠥ)-гээр тэмдэглэсэн хэрэг бус бөгөөд ер нь, монгол хэлний ö, ü эгшиг ихэнх нутгийн аялгуунд сэлгэдэгтэй холбоотой асуудал юм. Тэгвэл ö эгшиг нь дангаараа юм уу č, j, n, b гийгүүлэгчээс бусад тохиолдолд болон үгийн хоёрдугаар үеэс хойш яагаад тэмдэглээгүй вэ. Чоб-хэ Мун-о-д монгол бичгийн хэлийг хангылаар галиглахдаа m гийгүүлэгчийн дараа мөн тэмдэглэсэн байна. Тэгвэл, d, t гийгүүлэгчийн дараа тэмдэглэсэн жишээ л байхгүй гэсэн үг. Энэ нь мөн d,

<sup>4</sup> r ба l нь солонгос бичигт үсгийн нэг махбодиор тэмдэглэдэг.

<sup>5</sup> И Ги Мүн(이기문), 「蒙語老乞大研究」, 『震檀學報』 第五十五.六.七號 台本, 1964, p.367-426. Мөн Чон Жэ-Мүн(정제문): ...Үгийн эхэнд л ö, ü-г ялган тэмдэглэсэн нь b, č, j, m, n-гийн дараа л тохиолдох ба d, t, g, k, s-ийн дараа ялгаж тэмдэглээгүй байна. Үүний учир нь l-рт, тухайн авианы урагшилсантай, эсвэл 18-р зууны солонгос хүмүүсийн ойр харилцаатай байсан монгол хэлний ямар нэгэн нутгийн аялгуутны онцлогтой холбогдоно. З-рт, Солонгос хүмүүс монгол хэлний эдгээр гийгүүлэгчийн дараах ö ба ü-г ялган сонсож чадаагүй гэсэн гурван таамаглалын нэг болох юм(정제문, 「『蒙語類解』의 몽골어에 대한 연구」, 弘文閣. 1992:13) гэжээ.

t гийгүүлэгчийн дараа зарим нутгийн аялгуудад ö, ü сэлгэдэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, *Монгол хэлний гурван ном* -ыг тэмдэглэсэн нутгийн аялгуу нь d, t гийгүүлэгчийн дараа ü-гээр их дууддаг нутгийн аялгуугаар бичсэн байж болно. ö, ü сэлгэдэг тохиолдол монгол орчин цагийн нутгийн аялгуудад маш олон тохиолдоно(tүvshīn ~ tövshīn; хөvгүн ~ хүvгүн; хүлүг ~ хдлөг; тdw ~ тüw). Хоёрдугаар үеэс хойш монгол бичгийн хэлэнд о ~ ö эгшиг ордоггүй байсан ба бүр эрт цагт монгол хэлэнд ö эгшиг байгаагүй гэж үзэх санал ч буй. Орчин цагийн зарим нутгийн аялгуунд, жишээ нь дагуурт ө байхгүй, мөн зарим нутгийн аялгуунд ө эгшигтэй үг хамгийн цөөн тохиолддог байна. Буриад хэлний олон аялгуунд ö, ü хоёрыг ялгагдаггүй ба ихэвчлэн ü-гээр хэлдэг байна. Жишээ нь, *üdü*, *übül*, *ündür*.

“*Монгол хэлний гурван ном*”-д жишээ нь, *Мун-о ну-гол-дэ*. müngü(0116a01); kübägün (0109b05); kügsin(0511a02) зэрэг үгийн эхний ö-г ихэвчлэн ü-гээр тэмдэглэсэн нь буриад зэрэг аялгуутай адил монгол хэлний нэгэн аялгуунд тулгуурласантай холбогдох ба хорчин, харчин аялгуунд ö эгшиг байхгүй. Мөн хорчины аман аялгуунд ö байхгүй ба эртний монгол хэлний ü-гийн байранд ü, e ба ü-гийн харилцан ижилслээс үүссэн ö-гийн байранд ихэвчлэн e эгшиг тохиолддог байна. Ер нь “*Монгол хэлний гурван ном*”-ыг монгол 12 толгой үсэгт тохируулан хангылаар тэмдэглэсэн ба “*Монгол 12 толгой үсэг*”(蒙文十二字頭)<sup>6</sup>-ийг үзвэл монгол хэлний нэг авианд солонгос хэлний нэг авиагаар дүйцүүлэн тохируулсан, ö, ü хоёрыг 2 тусдаа үсгээр тэмдэглэсэн зэргийг бүр баттай мэдэж болно.

Монгол 12 толгой үсэг							
Монгол бичиг	ᠠ	ᠡ	ᠢ	ᠣ	ᠤ	ᠥ	ᠦ
Хангыл	아	어	이	오	우	워	우
Галиг	a	ə	i	o	u	ö	ü
Монгол бичиг	ᠪ	ᠬ	ᠬ	ᠪ	ᠪ	ᠪ	ᠪ
Хангыл	바	비	비	보	부	뷔	부
Галиг	ba	bə	bi	bo	bu	bö	bü
Монгол бичиг	ᠳ	ᠳ	ᠳ	ᠳ	ᠳ	ᠳ	ᠳ
Хангыл	하	가	히	호	고	후	구
Галиг	qa	ya	qi	qo	yo	qu	yu
Монгол бичиг	ᠷ	ᠷ	ᠷ	ᠷ	ᠷ	ᠷ	ᠷ

<sup>6</sup> “*Монгол 12 толгой үсэг*”(蒙文十二字頭) нь уулаасаа монгол үсгийн тогтолцоонд байсангүй. Манж нь уйгур монгол бичгийг өөрийн хэлэнд тохируулан авсны дараа Дахай багш Манжийн дусал бинтэт үсгийг зохиохдоо Манж 12 толгой үсгийг зохиосон байна. Түүнийг сүүлд монгол хэлэнд хуулан авсан хэрэг юм. Өөрөөр хэлбэл, Манж нь 1632 оны орчим 12 толгой үсгийг зохиож монгол хэлэнд 17-р зууны дунд үед авсан гэж бодож байна. “*Монгол 12 толгой үсэг*” нь хангыл сурвалжид мөн уламжилсан ба проф. И Ги Мүн(이기문, 蒙文十二字頭에 대하여, 1969) “*Монгол 12 толгой үсэг*”-ийн тухай танилцуулсан байна.

Хангыл	사	서	시	소	수	쉬	수
Галиг	sa	sə	si	so	su	sö	sü
Монгол бичиг	ᠰᠢ	ᠰᠢ	ᠰᠢ	ᠰᠤ	ᠰᠤ	ᠰᠢ	ᠰᠢ
Хангыл	샤	셔	시	쇼	슈	쉬	슈
Галиг	ša	šə	ši	šo	šu	šö	šü
Монгол бичиг	ᠰᠢ	ᠰᠢ	ᠰᠢ	ᠰᠤ	ᠰᠤ	ᠰᠢ	ᠰᠢ
Хангыл	자	저	지	조	주	쥐	주
Галиг	ja	jə	ji	jo	ju	jö	jü
Монгол бичиг	ᠵᠢ	ᠵᠢ	ᠵᠢ	ᠵᠤ	ᠵᠤ	ᠵᠢ	ᠵᠢ
Хангыл	게	거	기/기	쿠	구	귀	귀
Галиг	ke	ge	gi	kü	gü	kö	gö
Монгол бичиг	ᠬᠡ	ᠬᠡ	ᠬᠡ	ᠬᠤ	ᠬᠤ	ᠬᠢ	
Хангыл	타	다	태	테	티	디	
Галиг	ta	da	te	de	ti	di	
Монгол бичиг	ᠲᠢ	ᠲᠢ	ᠲᠢ	ᠲᠤ	ᠲᠤ	ᠲᠢ	ᠲᠢ
Хангыл	토	도	투	두	튀	뒤	투/두
Галиг	to	do	tu	du	tö	dö	tü/dü
Монгол бичиг	ᠲᠢ	ᠲᠢ	ᠲᠢ	ᠲᠤ	ᠲᠤ	ᠲᠢ	ᠲᠢ
Хангыл	마	머	미	모	무	뮌	무
Галиг	ma	me	mi	mo	mu	mö	mü
Монгол бичиг	ᠮᠠ	ᠮᠠ	ᠮᠠ	ᠮᠤ	ᠮᠤ	ᠮᠢ	ᠮᠢ
Хангыл	나	너	니	노	누	뉌	누
Галиг	na	ne	ni	no	nu	nö	nü
Монгол бичиг	ᠨᠠ	ᠨᠠ	ᠨᠠ	ᠨᠤ	ᠨᠤ	ᠨᠢ	ᠨᠢ
Хангыл	라	러	리	로	루	뤌	루
Галиг	ra	re	ri	ro	ru	rö	rü
Монгол бичиг	ᠷᠠ	ᠷᠠ	ᠷᠠ	ᠷᠤ	ᠷᠤ	ᠷᠢ	ᠷᠢ
Хангыл	라	러	리	로	루	뤌	루

Галиг	la	le	li	lo	lu	lö	lü
Монгол бичиг	ᠯᠠ	ᠯᠡ	ᠯᠢ	ᠯᠣ	ᠯᠤ	ᠯᠥ	ᠯᠦ
Хангыл	야	예	이	요	유	유	유
Галиг	ya	ye	yi	yo	yu	yö	yü
Монгол бичиг	ᠶᠠ	ᠶᠡ	ᠶᠢ	ᠶᠣ	ᠶᠤ	ᠶᠥ	ᠶᠦ
Хангыл	차	체	치	초	추	취	추
Галиг	ča	če	či	čo	ču	čö	čü
Монгол бичиг	ᠴᠠ	ᠴᠡ	ᠴᠢ	ᠴᠣ	ᠴᠤ	ᠴᠥ	ᠴᠦ
Хангыл	파	페	피	포	푸	퓌	푸
Галиг	pa	pe	pi	po	pu	pö	pü
Монгол бичиг	ᠯᠠ	ᠯᠠ	ᠠ	ᠠ			
Хангыл	하	가	호	고			
Галиг	qa	ya	qo	yo			
Монгол бичиг	ᠬᠠ	ᠬᠡ	ᠬᠢ	ᠬᠣ	ᠬᠤ		
Хангыл	차	체	츠	초	추		
Галиг	cha	che	chi	cho	chu		
Монгол бичиг	ᠬᠠ	ᠬᠡ	ᠬᠢ	ᠬᠣ	ᠬᠤ		
Хангыл	차	체	츠	초	추		
Галиг	tša	tše	tši	tšo	tšu		
Монгол бичиг	ᠯᠠ	ᠯᠠ	ᠠ	ᠠ	ᠠ		
Хангыл	와	워	카	디	기운		
Галиг	wa	we	k'a	di	uud		

*Хос эгшиг.*

Хангыл галигийн ㅑ (iya, ya); ㅓ (ayi, ai); ㅕ (iye, yə); ㅗ (eyi, ei); ㅛ (oyi, oi); ㅜ (uyi, ui, üyi, üi) үеэр монгол бичгийн хэлний iya, ayi, iye, eyi, oyi, uyi, üyi үеийг тэмдэглэсэн үү, орчин цагийн монгол хэлний яа, еэ, юу, юу, ай, эй, ой, уй, үй хос эгшигийг тэмдэглэсэн үү. И Ги Мүн(1964) бүтээлдээ жишээ аван галиглахдаа монгол бичгийн эхэд нь iya, ayi, iye, eyi, oyi, uyi, üyi үе тохиолдож буй газар iya, ayi, iye, eyi, oyi, uyi, üyi-гээр, өөрөөр хэлбэл монгол бичгийн эхийг барьжээ. Гэвч хангыл үсгийн галигаас үзвэл, монгол бичгийн iya, ayi, iye, eyi, uyi, üyi үеийн дуудлага цэвэр хос эгшиг болсныг тэмдэглэсэн нь олон тааралдах ба жишээ нь,

- Монгол бичгийн эхэд үгийн үндэс хувилахад үгийн төгсгөлийн үеийн *ya, ai, yə, ei, oi, ui, üi* нь хувилж *iya, ayi, iye, eyi, oyi, uyi, üyi* болсон тохиолдолд хажуугийн хангыл галигт ㅑ (ya); ㅓ (ye); ㅕ (yə); ㅓ (ei); ㅗ (oi); ㅜ (ui, üi) огт хувираагүй. Жишээ нь, *Мун-о ну-гол-дэ*.

*a. mb. qorma᠗i ~ han. qorma᠗i(0219a03) b. mb. qulayai ~ han. qulayai(0711a03);*  
*mb. qormayibči ~ han. qorma᠗bči(0817b05) mb. qulayayiči ~ han. qulayaiči(0211a01)*

- Монгол бичгийн хэлний нэг үгийн үндэс бүхий үгийг хангыл галигт хоёр хувилбараар тэмдэглэсэн алдаа нь монгол бичгийн хэлний *iya, ayi, iye, eyi, oyi, uyi, üyi* үеийг хангыл үсгээр тэмдэглэх бололцоо байсан ч тэгсэнгүй, тухайн үеийн дуудлагад нь тааруулж тэмдэглэсний нэгэн баталгаа болох юм. Жишээ нь, *Мун-о ну-гол-дэ*.

*a. mb. tariyalang ~ han. tariyalan(0717a05) b. mb. tariyan ~ han. taryan(0322a07, 0722b06).*

*Урт эгшиг.*

*Мун-о Ну-гол-дэ (蒙語老乞人)-д урт эгшгийг гурван хэлбэрээр тэмдэглэсэн:*

*Нэгдүгээрт, орчин цагийн монгол хэлний урт эгшгийн байранд эртний монгол хэлний VCV бүтэц бүхий үг хамгийн олон тохиолдоно.*

*mb. qoɣoɣondu ~ han. qoɣoɣondu (0520b03); mb. ečiged ~ han. ečigəd (0420b04)*

*Хоёрдугаарт, Эртний монгол хэлний VCV бүтцийн доторх хоёр эгшгийн дундах гийгүүлэгч сугарсан боловч хоёр талын эгшиг бүрэн ижилсээгүй жишээ олонтоо тааралдана. Эдгээр жишээ нь дундад үеийн монгол хэлний дурсгалуудад цөөн тэмдэглэгдэх болжээ.*

*mb. qaɣuɕid-iyar ~ han. qaučidar(0102a06); mb. degüü-ner ~ han. dəü<sup>2</sup>nər(0505b02)*

*Гуравдугаарт, Ихэвчлэн VCV-ийн хоёр талын эгшиг ижил эгшиг байсан тохиолдолд ижилсэж урт эгшиг үүссэн байжээ.*

*mb. ayulju ~ han. aalju(0211b01); mb. бүдүгүн ~ han. бүдүн(0607b06)*

## 2.2 Гийгүүлэгчийн тохиролцоо

Монгол хэлний гийгүүлэгч авиануудаас монгол бичгийн эр, эм үгийн *γ/g*-г (ᠭ)-гээр мөн хажуугийн *l*, чичрэх *ɣ*-ийг (ᠨ)-ээр тэмдэглэсэн ба энэ нь хангыл үсгийн тэмдэглэх боломжоос шалтгаалсан асуудал юм. Монгол бичгийн *γ/g* (ᠭ) гийгүүлэгчийн тухайд эр эм үгэнд орсноор ялгах тул хангыл галигаар нэг үсгээр тэмдэглэснийг уншихад асуудалгүй бөгөөд *l* болон *ɣ* гийгүүлэгчийн хувьд монгол бичгийн эхийг барин уншихад болно. Монгол бичгийн хамжин шүргэх *j, č*-г *ya, ye, yo, yö, yu, yü* гэсэн хос эгшгээр амилуулсан. Жишээ нь,

*ᠵᠠ(jya), ᠵᠡ(jye), ᠵᠠ(jyo), ᠵᠢ(jyu, jyü); ᠴᠠ(čya), ᠴᠡ(čye), ᠴᠠ(čyo), ᠴᠢ(čyu, čyü).*

*dz, ts*-г тэмдэглээгүй ба энэ нь хангыл үсгийн боломжоос юм уу, монгол нутгийн аялгууны онцлогтой холбогдох бололтой. Хорчин аман аялгуунд хамжин шүргэх *z, c* байхгүй.

Шүргэх *š*-ийг мөн дээрх мэт амилуулсан монгол бичгийн хэлний *š*-ийг *s*-ээс ялган тэмдэглэсэн хэрэг юм. *ᠰᠠ(šya), ᠰᠡ(šye), ᠰᠠ(šyo), ᠰᠢ(šyu, šyü)*. Мөн монгол бичгийн хэлний гадаад үгийг тэмдэглэх *z*-г хангыл галигт тэмдэглэх боломжгүйгээс *j*-тэй адилаар галигласан. Жишээ нь, *mb. mengzi ~ han. mǐnjǐ (0103a05); mb. dengzi ~ han. dīngjǐ (0803a06)*

<sup>2</sup> Бас манж хэлэнд *deo* гэж бичээд *deü* гэж дууддаг нь хоёр талын эгшиг нь бүрэн ижилсээгүй байх үед манж хэлэнд орсон монгол үг гэж үзэлтэй.

### 3. Авнаны хувьсал

#### 3.1 Эгшигийн ижилсэл

- Монгол бичгийн хэлний 2-р үеэс хойших гэдэс(ө)-ийг *и* юм уу *й* байсан гэж үзсээр ирсэн билээ. Гэвч 17-р зууны монгол хэлэнд эр үгэнд уруулаар ижилсэж тэргүүн бус үед *о* эгшиг болж хэдийн хэвшсэн нь хангыл үсгийн галигт тодорхой тэмдэглэжээ. Жишээ нь, *Мун-о ну-гол-дэ*. qoloqan(=qolaqan)(0225b01); toryo(=tory-a)(0608b04). Гэхдээ 3-р үеийн уруулын бус эгшиг уруулын эгшигтээ ижилсэж амжаагүй байжээ. dotoran(0718a03); jolyoysan(0121b03).

Орчин цагийн халх аялгуунд уруулын эгшигтээ ижилссэн бол, ойрад аялгуунд 2-р үеийн богино эгшиг балархайшиж 3-р үеийн уруулын бус эгшиг хэвээр үлдсэн байна. Ойрад аялгуутай адилаар *Мун-о Ну-гол-дэ*-д 2-р үеийн эгшиг тэргүүн үеийн уруулын эгшигтээ татагдан ижилссэний дараа 3-р үед байсан уруулын бус эгшиг бүрэн ижилсэлгүй уруулын ба уруулын бус эгшиг бүхий 2 үет үг үүссэн байна. Жишээ нь, *Мун-о ну-гол-дэ*. dökən(0811a01) < mb. dōgeken.

Мун-о Ну-гол-дэ-д тохиолдож буй нэгэн сонирхолтой онцлог бол уруулын эгшиг уруулын бус эгшигтээ татагдан ижилссэн байна. han. tāmər(0701b03) ~ kh. tömör(mb. temür); han. dərβən(0821b01) ~ kh. dörvön<sup>8</sup>(mb. dörben); han. qoyala(0402b02) ~ kh. xoyulā(mb. qoyayula). Ийм жишээ Бээжин барын Гэсэрт цөөнгүй тохиолддог. Geser. tabdayar(0569b10)~ kh. tavdugār(mb. tabuduyar); Geser. kegeji(0145a19) ~ kh. xōdž(mb. kögegejü) гэх мэт. Энэ үзэгдэл нь 17-18-р зууны монгол хэлний нэгэн онцлог байсан бололтой. Орчин цагийн буриад, халимаг аялгуунд дараах мэт жишээнүүд олонтоо тохиолдоно. buriad. eberte ~ kh. övört(mb. ebür-tü); xalimag. erk ~ kh. ör^x(mb. erüke)<sup>9</sup>.

Уруулын эгшигийн нөлөөгөөр ижилссэн эгшигийн жишээнүүдэд хангыл галигт орчин цагийн монгол хэлний 'u' эгшигийн байранд 'o' эгшигийг тэмдэглэсэн олонтоо тохиолдоно. *Мун-о ну-гол-дэ*. han. ibcōo(0607b07) < mb. ibčayū > kh. yavtsū; han. qalon(0511b03) < mb. qalayun > kh. xalūn; han. jaora(0410a05) < mb. jayur-a > kh. dzūr; han. qaoli(0522a04) < mb. qauli<sup>10</sup> > kh. xülī; han. taolai(0704b05) < mb. taulai > kh. tülāi.

Монгол хэлний олон аялгуунд *у* болсон эдгээр үгсийг зарим эрдэмтэд *о*, *у* хоёрыг нэг үсгээр тэмдэглэсэн гэдэг юм уу, солонгос хүн монгол хэлийг буруу дуудлагаар тэмдэглэсэн гэж болох ч зохиогчийн үзэхээр энэ нь тухайн үеийн нутгийн аялгууны онцлогийг тусгасан байх боломжтой юм. Монгол хэлний олон аялгуунд *ayu* > *au*-гаас урт эгшиг *u* үүссэн бол монгол

<sup>8</sup> Мун-о Юү-хэ-д мөн тохиолдоно. *derben*(p.19) < mb. dörben > kh. dörbön

<sup>9</sup> Авиа дэвших юм уу, ухран ижилсэж уруулын эсвэл уруулын бус эгшгүүд нэг үгэнд орох болсноор нутгийн аялгуудад нэг үгийн олон дуудлагыг бүтээж орчин цагийн монгол хэлний төв аялгуунд зарим тохиолдолд аль аль нь зэрэгцэн оршиж монгол хэлний үгийн санг баяжуулж байна. Жишээ нь, *kedürekü* гэсэн эртний монгол хэлний үгээс ухран ижилшсэн *хөдрөх*, дэвшин ижилшсэн *хэдрэх* гэсэн хоёр хувилбар бий болж аль аль нь халхын нутгийн аялгуудад зэрэгцэн оршиж толь бичигт ч адил утгатай үгийн хоёр хувилбараар хоёр толгой болгон тэмдэглэжээ. Ер нь 17-18-р зууны үед уруулын болон уруулын бус эгшгүүд хоорондоо ижилссэн нь монгол хэлний бүх нутгийн аялгууны онцлог байсан ба аль ч нутгийн аялгуунд нэг үгийн хоёр хувилбар гэдэг нь ойлгомжтой байгаад орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуудад аль нэг нь хуучирч аль нэг нь идэвхтэй хэрэглэгдэх болсон бололтой.

<sup>10</sup> Монгол бичгийн *ᠲᠠᠣᠯᠠᠢ* *taulai*, *ᠲᠠᠣᠯᠢ* *teüke* зэрэг онцгой бичлэгтэй үгс нь хоёр өөр эгшигийн гийгүүдэгчийн сулралыг шууд тусган тэмдэглэсэн үеийн онцлог монгол бичгийн зөв бичих зүйд хэвшин тогтсон хэрэг юм.

хэлний дархад аялгуунд о: болсон байна. Жишээ нь, Dar. хо:li < mb. qauli > kh. xūli; Dar. о:olo < mb. ayula > kh. ūlā; Dar. то:ха < mb. tauqai > kh. tūxāi. Мөн харчины аман аялгуунд үгийн 1-р үед монгол бичгийн хэлний ау нь оо болдог байна. Жишээ нь, ōl, tōlā гэх мэт. Үүнтэй адил зарчимтай жишээнүүд хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалд ч тохиолдоно. Гэхдээ *Мун-о ну-гол* дэ-д дээрх мэт хувирал бүхий үгэнд у эгшгээр тэмдэглэсэн жишээ ч олон тохиолдоно. *Мун-о ну-гол-дэ*. jau (0513a03) < mb. jaγun > kh. džū; qajau (0202a06) < mb. qajayu > kh. xadžū

### 3.2 Гийгүүлэгчийн сугарал

Д.Төмөртоого, 'Дундад үеийн монгол хэлний хоёр эгшигийн хооронд байсан шүргэх -y/g- гийгүүлэгчийн арын урт эгшиг өмөнөх гийгүүлэгчээ суларуулах нөлөөтэй байсан бол түүний өмөнө талын богино i эгшиг нь түүнийг тагнайшуулах нөлөөтэй байжээ'<sup>11</sup> гэжээ. Энэхүү авианы хувирлыг дундад монгол хэлний жишээгээр тайлбарлаж, дундад монгол хэлний онцлог гэж үзсэн байдаг. Гэтэл Мун-о Ну-гол-дэ-гийн хэлэнд бүрэн ижилсэнээсээ илүүтэйгээр хоёр эгшигийн хоорондох гийгүүлэгч сугарч хоёр талын эгшиг бүрэн ижилсэж амжаагүй жишээ маш системтэйгээр тохиолдож байна.

*Мун-о ну-гол-дэ*. amaraolju (0410a03) < mb. amarayulju > kh. amrūldž

*Мун-о ну-гол-дэ*. äünäcä(0311a05) < mb. egün-eče > kh. ünēs

Хоёр өөр үеэс бүтсэн, тухайлбал о + а, а + u, е + ü хос эгшиг бүхий үгс нь урт эгшигийн байдалтай бололгүйгээр урт хугацааны турш могол, дагур хэлэнд тохиолддог шиг байсаар байсан<sup>12</sup> гэж үзэх нь ч бий. Гийгүүлэгчийн хоёр талын эгшиг нь ижил байсан цогцоос бүрэлдсэн үүсмэл урт эгшигийн хамаатах цаг нь дундад үеийн монгол хэлний үед хамаарах бол хоёр өөр эгшиг бүхий цогцоос улирсан үүсмэл урт эгшиг нь дундад монгол хэлний эхэн үед бий болоод энэхүү бүрэн ижилсээгүй хэлбэр нь 17-18-р зууны монгол хэлэнд ч байсаар байсан ба 17-18-р зууны монгол хэлний хамгийн гол онцлог байж орчин цагийн нутгийн аялгуудад ухран юмуу дэвшин ижилсжээ.

Мун-о Ну-гол-дэ-д тохиолдож буй эртний монгол хэлний V + y + V цогцын у гийгүүлэгч сугарснаар зөвхөн хос эгшиг бус урт эгшигийг тэмдэглэсэн тохиолдол цөөнгүй.

han. kəjə(0504b02) < mb. kejy-e > kh. xedzē; han. kədün(0110a02) < mb. kedüyin > kh. xedī

Гэхдээ эдгээр жишээ нь зөвхөн эм эгшигт үгэнд тохиолдоно. Эгшгүүд дотроос хамгийн уйтан шинжтэй эгшиг бол и эгшиг бөгөөд бусад авиаг өөртөө татан ижилсүүлэх талаар сул, харин өөр авианы нөлөөнд автаж ижилсэх нь их байдаг байна. Монгол хэлний хэлний хойгуурх, эр, чанга *а, о, и*-тай *i* эгшиг ижилсэхэд хугацаа их шаардах ба удаан хугацааны туршид хос эгшигийн байдалтай байдаг бол, хэлний дундуурх, уйтан, сул, эм *е, ө, й*-тэй уйтан *и* эгшиг нь татагдаж ижилсэх нь дөхөм байдаг байна. Үүний нэг баримт нь орчин цагийн

<sup>11</sup> Д.Төмөртоого, *Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд*, Улаанбаатар, 2002, 139-140-р тал. Мөн Sh.Hattori(1970, p. 186-194), N.Popper(1962, p. 1-19), Ш.Лувсанвандан(1966, 5-26-р тал) нар хоёр эгшигийн дундах y/g гийгүүлэгч арынхаа өргөлтөөс үүсэлтэй урт эгшигийн нөлөөгөөр сулран сугарсан гэж үзсэн. Энэхүү гийгүүлэгчийн сугарлын улмаас урт эгшиг гийгүүлэгчийн өмнө байсан балархай богино эгшигийг ижилсүүлсэн гэж үздэг.

<sup>12</sup> Г.Д.Санжеев, *Сравнительная грамматика монгольских языков*, I, Москва, 1953. стр. 78.



монгол хэлэнд ч *ei*<sup>13</sup>, *ii* хос эгшгээс илүү *ээ*, *үү* урт эгшиг тохиолдож, *öi* хос эгшиг бүр байхгүй ба *öö* урт эгшиг болсон байна.

Мун-о Ну-гол-дэ-д тохиолдож буй нэг сонирхолтой баримт бол орчин цагийн монгол хэлний хос эгшгийн байранд, монгол бичгийн хэлний V + y + V цогцыг хангыл үсгээр ʃ (ya)-гаар тэмдэглэсэн жишээнүүд юм. Өөрөөр хэлбэл V + y + V сугарч урт юм уу хос эгшиг болсонгүй, у гийгүүлэгчийн өмнөх эгшиг балархайшсан байна. Мун-о ну-гол-дэ. jisiyalaju (0218a04) < mb. jisiyalaju > kh. dzasäldž; Мун-о ну-гол-дэ. qubyaaji (0518b05) < mb. qubiyaju > kh. xuvädž. Халх аялгуунд урт эгшиг болсон эдгээр үгсийг яагаад 17-р зууны монгол хэлний сурвалжид -яа-гаар тэмдэглэсэн бэ. Тухайн үед монгол хэлнээс салсан буриад, ойрад аялгуунаас хайвал, үгийн тэргүүн болон дэд үеийн V + y + V цогцын эхний эгшиг бүрэн балархайшиж, у гийгүүлэгч нь эхний үеийн эгшигтэйгээ зохицон ижилсэж -уа-, -уи- үеийг бүтээжээ. Тухайлбал, 'Монголын нууц товчоон'-ы буриад, ойрд орчуулгад дараах жишээнүүд тохиолдоно.

МНТ(&16): bur. zakya < mb. jakiy-a > kh. dzax`ā; МНТ: uyila`ad, hal. uulyad < mb. uyilayad > kh. uilād

Ялангуяа -ban, -γad, -γul нөхцөлүүд нь буриад аялгуунд -yad<sup>2</sup>(mb. -γad<sup>2</sup> > kh. -aad<sup>1</sup>), -ya<sup>2</sup>(mb. -ban<sup>2</sup> < 17Mo. -γan<sup>2</sup> < -aa<sup>1</sup>), -yul(< mb. -γul<sup>2</sup> > kh. -uul<sup>2</sup>) болж хөгжжээ.

### 3.4 Гийгүүлэгчийн сэлгэлт

Монгол нутгийн аялгуудад хамжих *d, t*, хамжин шүргэх *j, č*, хамжих *b, g/γ, q/k* гийгүүлэгч сэлгэх тохиолдол олон байдаг. Тиймээс ч эдгээр авиануудыг сэлгэдэг онцлогоор нь бодож монгол бичигт хоёр хоёроор нь адил үсгээр тэмдэглэсэн билээ. Мун-о Ну-гол-дэ-д тэдгээр монгол бичгийн хэлний адил дүрс бүхий авиануудыг ялган тэмдэглэсэн ба энэ нь Мун-о Ну-гол-дэ-н болоод тухайн үеийн авианзүйн онцлогийг тодруулахад дөхөм болох юм. Орчин цагийн халх аялгуунаас хамгийн их ялгаатайгаар тэмдэглэсэн онцлог бол *d ~ t*-гийн сэлгэлт юм.

han. naitasan(0505b07) ~ kh. naidāsān(mb. nayidaγsan); han. qodoγotu(0704a06) ~ kh. xodōd(mb. qodoγodu); han. quntaγa(0508b04) ~ kh. xundāgā(mb. qundaγ-a).

Мөн *g/γ ~ q/k* хоорондоо их сэлгэснийг хангыл галигт тэмдэглэсэн байна. han. čikirsü(0208b06) ~ mb. čigirsü; han. sikira(0704a05) ~ mb. sigir-e; han. түгәi(0316a07) ~ mb. tükei.

Дундад үеийн монгол хэлэнд *g/γ ~ q/k*-гийн ялгамжаа бага байснаа 17-р зуун болж ирэхэд уг хоёр авиаг ялгах болж ирсэн нь дараах дундад үеийн монгол хэлний сурвалж болох 'МНТ' болон 17-р зууны 'Алтан товч'-ийн харьцуулсан галигаас харагдана.

[SHM&78].... qala`un-aca minu qalat qarurun

[LAT 18a].... qalayun-ača minu qaγal-un γarur-un

<sup>13</sup> 17-18-р зууны хос эгшиг *ei* нь халхад *ii*, буриадад *ei*, халимагт *ii*, дагуурт *ee* болж хувирчээ. Өөрөөр хэлбэл хос эгшгийн хэлбэрээр зөвхөн буриад аялгуунд үлджээ.

[SHM&78]... *qar-dur-iyān qara nōdūn hatqun töreliḡi*  
 [LAT 18a]... qara čisun *qar-tur-iyān adqun törügŋsen bülüge*<sup>14</sup>

гэсэн q-гаар толгойлсон шүлэгт МНТ-д мөрийн эхэнд *qar* гэсэн бичлэг бүхий гар гэсэн утгатай үгийн ү дундад зууны монгол хэлэнд *q* байгаад 17-р зууны монгол хэлэнд ү болсон тул *q*- толгой бүхий уг шүлэгт тохиромжгүй болж хойд талын q-гаар эхэлсэн үгтэй байрыг нь сольж найруулсан байна.

### 3.5 Гийгүүлэгч давхарлах ёс

Харьяалахын тийн ялгал болон заахын тийн ялгалыг залгахдаа эгшгээр төгссөн юм уу -n гийгүүлэгчээр төгссөн үгэнд -n- гийгүүлэгчийг жийрэглэсэн.

*Мун-о ну-гол-дэ. qalon-niki(0409a01) < mb. qalayun-i*  
*Мун-о ну-гол-дэ. küitän-niki(0409a02) < mb. küiten-i*

Энэхүү авианы онцлог нь 17-18-р зууны монгол хэлний бусад дурсгалууд болох Гэсэрийн тууж болон хэвтээ дөрвөлжин бичгийн дурсгал, манж толь зэрэгт ч цөөнгүй тохиолдоно.

Geser: sayinnar(0115a18) < mb. sayin-iyar > kh. sainār; Geser: čilayun-ni(1354a19) < mb. čilayun-i > kh. chulünig; H.Dö. kan-nu (P.B, 2005, 64) < mb. kaγan-u > kh. xānī; ma. töbed modon-nu<sup>15</sup>

Ихэвчлэн урт эгшигт үгийн өмнө, хойно тохиолдох энэхүү давхар гийгүүлэгч нь урт эгшигийн нөлөөгөөр тухайн гийгүүлэгчийг урт хэлж байсныг бичигт тэмдэглэсэн байж болох юм.

### Товч дүгнэлт

'Монгол хэлний гурван ном' зохиогчийн үгээс үзвэл Бээжингийн монголчуудын аялгуунд суурилсан нь тодорхой юм. Төгсгөлийн үгийг сийрүүлбэл,

Manai surγayuli-yin tüsimed-ün ungsiqu bolbasurayulqu mongγol bičig kedü bui bolbači üsüg-ün ayalyu üjüg-ün dürim bilig arγ-a üsüg neyileüljü kereglekü qauli büdegirebei. Eyimü-yin tula jobaysan anu udabai. Teneg bi köke bečin jil Beijing ečiküi-dü Qan-šyan-šü luu-tu sayurin-u emün-e ayiladqaju arban qoyar toloyai bičig-ün üjüg-ün ayalyu-yi jalarayul-un jasayul kemegsen-ü tula. Ging balyasun-du kürčü ečigsen-ü qoyin-a tusiyalyaju jasabasu jokiku kümün-i güičedken toyorin erigseger jabsiyān-iyar qoyar jerge-yin tüsimel Kioi-müng-qün nerlekü mongγol kümün-i učarayad arban qoyar toloyai-yi bičiged üsüg-ün bilig arγ-a ayalyun-u könggen kündü-yi naribčilan temdeglegsen-i ni olju abčiraysan bile. kökegčün takiy-a jil-ün jun-u dumda sar-a-du üsüg seyilükü yamun-du jarliy bayulyaju seyiljü daruyad tarqayabai. ene čay-tu yamun-u terigüleḡsen tüsimel Qüng sayid bas egüni jobamui. Edüḡe buliyaldun bolbasurayulqu debter-ün tasiyaraysan γajar-i jiči jalarayul-un jasabasu

<sup>14</sup> Ш.Чоймаа "Монголын Нууц Товчоон", Лувсанданзаны "Алтан товч"-ийн эхийн харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2002-35.

<sup>15</sup> Мөн (-n-)+(-g-); (-ng-)+(-g-); (-g-/γ-)+(-g-) гийгүүлэгч давхарласан нь нийтлэг тохиолдоно. Мөн ижил гийгүүлэгчид давхарлахаас гадна хэлэхүйн аль нэг шинжээрээ төстэй гийгүүлэгчид зохицон давхарласан байна. Geser: čotung-gi-yin(0142b15) < mb. čotung-un > kh. Tsotongin; Geser: čerig-gini(1376b22) < mb. čerig-i-ni > kh. tserig ni; H.Dö. kamug-gi(P.B, 2005, 69) < mb. qamuy-i > kh. xamgig; Ma. čaling-gün. Хэвтээ дөрвөлжин үсгийн сурвалжид (-d)+(-d-) давхарласан жишээ буй. H.Dö. nuγud-di (5a.1) < mb. nuγud-i > kh. nugüdig

sayin bolumui j-a kemen mön-kü jil alba yaγum-a bariju mörgür-e ečiküi-dü teneg namayi tusqayilan ilgekü-yin tula Mügden jangjun yamun-u janggi Bu-lo kemegči mongyol kümün-dü tusiyalyaju nige nigen-iyer jalarayul-un tasiyaran bičigsen üsüg tasiyaraysan üge-yi čöm qalan jasaju qoyitu üy-e-dü qočoroba. Ene mön-kü olan sayid-ud-un gün sanayan bui j-a. Teneg bi olan sayid-un kedü jaruydaju qarγaljaqu bui j-a. Suruysan medegsen anu meküs, üjegen sonusuysan inu basa čögen bišwü. Kerber ter narin niyuča yajar bolbasu tür qoyidu edür medegči kümün-yi küliyemüi.

Tngri-yin tedkügen-ü qučün negdüger on. Namur-un terigün sar-a-yin sayin edür. Suryaqu daruy-a Li-e-čing kičiyenggülen oyilamui. Mongyol bičig-ün surγayuli-yin tüsimel Li-šü-yüwan bičimui.

Мөн сурвалжийн хэлний онцлогоос ч Бээжингийн монгол буюу манжижсан монгол хэлтний аялгуунд тулгуурласан нь харагддаг. Тухайн үеийн Бээжингийн монгол хэлтэн нь манжийн төрд зүтгэсэн өвөг дээдсийнхээ зэрэг хэргэмийг дагасан монгол мөртлөө манж нөлөө бүхий хэлтэн болж хувирч, манжийн дотоод найман хошууны харьяат байжээ. Тэдгээр монголчууд дотор халхууд ч байсан байна. Монголын том ноёдыг дагасан монгол хошууд нь манжид дагаар орсон байсан тэр үед бусад улсын Монголыг сонирхогчид ч Манжийн нөлөөнд бүхий Монголчуудтай илүү харилцаатай байсан нь ойлгомжтой юм.

Тиймээс ч Чоб-хэ Мун-о болоод монгол хэлийг манжаар галигласан зүйл хуваасан толь нь адил зарчимтай байгаа ба Бээжин юм уу Мүгдэнд гарсан тухайн үеийн 5 хэлний толь юм уу, 3 хэлний толь зэрэг зүйл хуваасан тольтой адил агуулга бүхий толийг ашигласан буй за. “Монгол хэлний гурван ном”-д харчин, хорчин аялгууны үгс, орчин цагийн халхын ‘u’ эгшгийн байранд харчин зэрэг аялгуунд тохиолдож буй ‘o’ эгшиг бий болсон авианы хувирлын жишээд, *ö* авиаг цөөн тэмдэглэсэн нь хорчин, харчин аман аялгуунд байхгүй болсон, монгол бичгийн хэлний а ба уруулын эгшгийн байранд тохиолдож буй урагшилсан эгшиг авиалбарын хувилбар нь хорчин, харчин, цахар зэрэг аялгуунд буй. мөн *čičig*; *čirig* зэргээр хамжин шүргэх гийгүүлэгчийн дараах е-г и-гээр тэмдэглэсэн нь цахар, хорчин, харчин зэрэг аялгуунд и-тэй дууддаг зэрэг олон онцлог таарч буйгаас үзэхэд “Монгол хэлний гурван ном”-ыг, ялангуяа Мун-о Ну-гол-дэ-г харчин, хорчины аялгуунд үндэслэжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.<sup>16</sup>

<sup>16</sup> Харчин, хорчин аялгуутнууд одоо Өвөрмонголын Жиримийн аймаг, Хөлөн буйр, Хар мөрөн, Гирин мужид сууж байна. Харчин, хорчин буюу дорнод монголчууд нь хүн амын тоогоор төв аялгуутны дараагаар ордог ажээ(С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан, *Орчин үеийн монгол хэл аялгуу*, Улаанбаатар, 1982, 65-р тал).

## ABSTRACT

In this paper, the author studies the peculiarities of phonetics and phonology in *Mong-hak-sam-sõ* and compared them to some characteristics of historical grammar of the Mongolian language. *The Three Books for the Study of Mongolian* written in Korean published in the late 18<sup>th</sup> century have become familiar in the sphere of the scientific field since the scholars and researchers have been studying it from the mid of 20<sup>th</sup> century. These books are considered to be rare monuments of Mongolian language phonology because Mongolian colloquial language of that time was recorded in both Mongolian script and Korean Hangeul script. Studying the language of the monument, we can see aspects of Beijing Mongolian or Manchurian Mongolian speakers' dialect of that period. During that period Mongolia was under the rule of Manchu so it is clear that Koreans who published these books based on the language of Mongolians who were influenced deeply by Manchu.

In *Mongolian Lao Ki-da*, there are many occurrences of words with local dialects of Inner Mongolians such as bičiba(mb. bičibe, kh. bichiv), külya(mb. küliy-e, kh. xüleey), bida(mb. bide, kh. bid) and kharchin and khorchin dialect words such as qoyala(kh. xoyulâ), qudaldy(mb. qudaldy-a, kh. xudaldâ) which originated as progressive assimilation of phonemes became similar; examples of words with vowel assimilation which originated from rounded harmony of long vowels or phonemic conversion historical sound change like the modern `u` vowel replaced by `o` which occurs in such dialects as kharchin which are qalon(mb. qalayun > kh. xaluun), jaora(mb. jayur-a > kh. zuur). In *The Three Books for the Study of Mongolian* the fact that ö phoneme is not written very few, it matches the disappearance of that phoneme in khorchin and kharchin dialect. Examples: müngü(kh. möngö; MN. kügsin > kh. xögshin) in Mongolian Lao Ki-da. Also allophones, which are found instead of 'a' and rounded vowels of classical Mongolian, are used in khorchin, kharchin and tsakhar dialects commonly. In *The Three Books for the Study of Mongolian*, 'e' after affricative consonants is written as 'i' in words like čičig; čirig. This also matches the pronunciation of khorchin, kharchin and tsakhar dialects. By analyzing these peculiarities, we can conclude that *The Three Books for the Study of Mongolian*, especially *Mongolian Lao Ki-da* was based on kharchin and khorchin local dialects.